



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2023.3.21 № ЦАТ-11/03/069

танай 2023.3.16 -ны № 23/026-Т

Г Агент хасах тухай Г

Танай компаниас ирүүлсэн агентыг хасах тухай хүсэлтийг хүлээн авлаа.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан журмын 6.7-д “Хороо үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас ирүүлсэн эрх бүхий албан тушаалтан болон брокер, агентын өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийн дагуу бүртгэл хийж, хариуг албан бичгээр мэдэгдэнэ.” гэж заасны дагуу Чулуунбат овогтой Энхтөрийг Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох бүртгэлээс хасаж, өөрчлөлтийг хийсэн болохыг мэдэгдье.

Дээрх журмын 6.5-д “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн агент өөрчлөгдөх, шинээр томилогдсон тухай мэдээллийг албан бичгээр улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд холбогдох баримт бичгийн хамт ирүүлж, бүртгүүлнэ.” гэж заасны дагуу агентын өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлж ажиллахыг зөвлөж байна.

